

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Далайн-Элбэрэлт өрхийн эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2024/67/НА-СТА-ТЗШ

<p>Цахим хуудас: www.audit.mn Мөрөн сум 2024 он</p>	<p>Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар Утас:88883317 Цахим хаяг: Erdenebaatara@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр Утас: 99089114 Цахим хаяг: Tegshdelgerb@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Б.Давааням Утас: 88095436 Цахим хаяг: Davaanyamb@audit.gov.mn</p> <p>Аудитор: Б.Ариунтуяа Утас: 99036832 Цахим хаяг: Ariuntuyab@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.02.26 № 01/95
танай _____-ны № _____-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ДАЛАЙН-
ЭЛБЭРЭЛТ ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ДАРГА Ц.БУЯННЭМЭХ ТАНАА

Хараат бус аудитын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Далайн-Элбэрэлт өрхийн эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Далайн-Элбэрэлт өрхийн эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Авлага данс өмнөх оноос 54,804.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны 11, 12 дугаар сарын гүйцэтгэлийн санхүүжилт олгогдоогүйгээс шалтгаалсан байна. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас шалтгааныг тодруулахад санхүүжилт хүрэлцээгүй болсон гэж тайлбарласан байна.

Аудитын гол асуудал

Хөвсгөл аймгийн эрүүл мэндийн газрын даргын 2023 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн А/77 дугаар тушаалаар үнэ төлбөргүй хуваарилагдан ирсэн эм, эмнэлгийн хэрэгслээс түүвэрлэн тоолоход 2023 оны 5 болон 10 дугаар сард хугацаа дууссан бүтээгдэхүүнүүд байна. Уг хугацаа дууссан бүтээгдэхүүнүүдийг ангилж ялгасан тэмдэглэгээгүй, хугацаа дууссан гэдгийг эмнэлгийн алба хаагчид мэдээгүй, шууд хэрэглэхэд бэлэн байдалтай байгаа нь нийтийн эрүүл мэндэд эрсдэл учирч болзошгүй нөхцөл байдал гэж үзээд журмын дагуу шийдвэрлэх талаар зөвлөмж хүргүүлж, дараагийн аудитаар анхаарах хэсэгт тусгалаа.

Бусад асуудлын хэсэг

Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2-т "Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн үзүүлэх Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9.1-д заасан

6724040131

тусламж, үйлчилгээний зардлыг тохиолдолд суурилсан төлбөрийн аргаар тооцож, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлнэ.” гэж заасны дагуу эрүүл мэндийн даатгалын сангаас 100 хувь санхүүжиж байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А.ЭРДЭНЭБААТАР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	50,454,350.11	104,532,217.57
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	4,671,187.69	85,865.06
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	4,671,187.69	85,865.06
3121	Төгрөг	4,671,187.69	85,865.06
31211	Төрийн сангийн харилцах	4,671,187.69	85,865.06
33	АВЛАГА	00.00	54,804,628.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	296,000.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	00.00	54,508,628.00
35	БАРАА МАТЕРИАЛ	45,783,162.42	49,641,724.51
351	Түүхий эд материал	23,157,085.94	25,414,268.03
35110	Тусгай зориулалттай материал	10,297,617.00	19,128,655.03
35130	Эм боох материал	12,859,468.94	6,285,613.00
354	Хангамжийн материал	22,626,076.48	24,227,456.48
35410	Бичиг хэргийн материал	00.00	85,000.00
35470	Бусад хангамжийн материал	22,626,076.48	24,142,456.48
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	491,745,867.25	492,439,545.13
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	491,745,867.25	492,439,545.13
392	Биет хөрөнгө	471,646,471.44	472,437,545.13
39201	Барилга, байгууламж, орон сууц	379,077,926.09	379,077,926.09
39202	Хуримтлагдсан элэгдэл	-32,672,149.61	-42,310,796.17
39203	Авто-тээврийн хэрэгсэл	12,750,000.00	12,750,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-3,585,937.50	-5,179,687.50
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	88,288,099.78	118,527,578.78
39206	Хуримтлагдсан элэгдэл	-25,575,769.31	-46,473,500.03
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	11,263,399.82	18,483,399.82
39208	Хуримтлагдсан элэгдэл	-4,515,484.66	-5,814,133.01
39214	Бусад үндсэн хөрөнгө	54,413,853.00	54,413,853.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-7,797,466.17	-11,037,095.85
393	Биет бус хөрөнгө	20,099,395.81	20,002,000.00
39301	Програм хангамж	137,500.00	137,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-40,104.19	-137,500.00
39303	Бусад биет бус хөрөнгө	20,002,000.00	20,002,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	542,200,217.36	596,971,762.70
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	542,200,217.36	596,971,762.70
51	Засгийн газрын хувь оролцоо	542,200,217.36	596,971,762.70
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	164,465,499.87	164,465,499.87
51101	Өмч: - төрийн	164,465,499.87	164,465,499.87
512	Хуримтлагдсан үр дүн	300,964,857.93	355,736,403.27
51210	Өмнөх үеийн үр дүн	300,964,857.93	300,964,857.93
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	54,771,545.34
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	76,769,859.56	76,769,859.56
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	542,200,217.36	596,971,762.70

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	840,692,047.15	952,987,760.70
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	127,102,100.65	100,152,555.90
120	Нийтлэг татварын бус орлого	127,102,100.65	100,152,555.90
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	121,430,080.65	84,604,955.90

1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	121,430,080.65	84,604,955.90
120009	Бусад орлого	5,672,020.00	15,547,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	713,589,946.50	852,835,204.80
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	713,589,946.50	852,835,204.80
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	713,589,946.50	852,835,204.80
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	931,388,519.31	898,216,215.36
21	УРСГАЛ ЗАРДАЛ	931,388,519.31	898,216,215.36
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	914,654,740.31	887,866,215.36
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	635,293,231.00	609,654,122.00
210101	Үндсэн цалин	635,293,231.00	609,654,122.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	76,530,999.30	73,141,489.81
210202	Тэтгэмжийн даатгал	76,530,999.30	73,141,489.81
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,456,249.97	8,727,511.29
210301	Гэрэл, цахилгаан	1,363,219.15	1,228,651.79
210302	Түлш, халаалт	9,543,906.75	7,236,295.00
210303	Цэвэр, бохир ус	549,124.07	262,564.50
2104	Хангамж, бараа материалын зардал	19,798,965.00	19,261,613.00
210401	Бичиг хэрэг	7,159,847.00	5,928,510.00
210402	Тээвэр, шатахуун	4,897,390.00	5,646,435.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,479,930.00	2,518,120.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	615,500.00	333,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	624,760.00	1,418,400.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	3,021,538.00	3,416,648.00
2105	Нормативт зардал	120,390,450.43	119,481,918.14
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	120,390,450.43	113,321,918.14
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	6,160,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,177,000.00	4,562,850.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	69,000.00	625,000.00
210604	Урсгал засвар	2,108,000.00	3,937,850.00
2107	Томилолт, зочны зардал	921,800.00	1,246,400.00
210702	Дотоод албан томилолт	921,800.00	1,246,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	715,702.00	1,477,006.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	350,000.00	1,080,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	49,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	73,436.00	33,936.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	00.00
210807	Газрын төлбөр	136,266.00	211,770.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	134,000.00	101,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	47,370,342.61	50,313,305.12
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,070,880.00	12,382,927.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,129,120.00	1,164,577.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	31,170,342.61	36,765,801.12
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,733,779.00	10,350,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,733,779.00	10,350,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	16,733,779.00	10,350,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-90,696,472.16	54,771,545.34
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-90,696,472.16	54,771,545.34

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	828,226,279.50	813,874,176.80
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,672,020.00	15,547,600.00
120	Нийтлэг татварын бус орлого	5,672,020.00	15,547,600.00
120009	Бусад орлого	5,672,020.00	15,547,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	822,554,259.50	798,326,576.80
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	822,554,259.50	798,326,576.80
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	822,554,259.50	798,326,576.80
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	813,254,139.37	798,059,999.43
21	УРСГАЛ ЗАРДАЛ	813,254,139.37	798,059,999.43
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	796,520,360.37	788,209,999.43
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	635,293,231.00	609,950,122.00
210101	Үндсэн цалин	635,293,231.00	609,950,122.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	76,530,999.30	73,141,489.81
210202	Тэтгэмжийн даатгал	76,530,999.30	73,141,489.81
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,456,249.97	8,727,511.29
210301	Гэрэл, цахилгаан	2,267,474.15	1,228,651.79
210302	Түлш, халаалт	8,639,651.75	7,236,295.00
210303	Цэвэр, бохир ус	549,124.07	262,564.50
2104	Хангамж, бараа материалын зардал	21,152,865.00	20,930,993.00
210401	Бичиг хэрэг	7,118,847.00	6,542,010.00
210402	Тээвэр, шатахуун	4,897,390.00	5,281,435.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,520,930.00	2,545,320.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	615,500.00	333,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,708,660.00	3,367,780.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	3,291,538.00	2,860,948.00
2105	Нормативт зардал	29,236,913.10	51,688,673.33
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	28,656,913.10	45,528,673.33
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	580,000.00	6,160,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,982,400.00	7,220,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,874,400.00	3,715,450.00
210604	Урсгал засвар	2,108,000.00	3,504,850.00
2107	Томилолт, зочны зардал	921,800.00	1,246,400.00
210702	Дотоод албан томилолт	921,800.00	1,246,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	705,902.00	1,477,006.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	350,000.00	1,080,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	73,436.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	73,436.00	10,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	00.00
210807	Газрын төлбөр	136,266.00	211,770.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	124,200.00	101,800.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,240,000.00	13,827,504.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,110,880.00	12,662,927.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,129,120.00	1,164,577.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,733,779.00	9,850,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,733,779.00	9,850,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	16,733,779.00	9,850,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>14,972,140.13</u>	<u>15,814,177.37</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	10,330,000.00	20,399,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	10,330,000.00	20,399,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	10,330,000.00	20,399,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	10,330,000.00	20,399,500.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-10,330,000.00</u>	<u>-20,399,500.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	4,642,140.13	-4,585,322.63
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	29,047.56	4,671,187.69
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,671,187.69	85,865.06

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	144,463,499.87	-874,413.00	-30,858,623.94	00.00	112,730,462.93
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	144,463,499.87	-874,413.00	-30,858,623.94	00.00	112,730,462.93
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	15,423,805.33	00.00	15,423,805.33
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	164,465,499.87	76,769,859.56	300,964,857.93	00.00	542,200,217.36
D01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	164,465,499.87	76,769,859.56	300,964,857.93	00.00	542,200,217.36
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	164,465,499.87	76,769,859.56	300,964,857.93	00.00	542,200,217.36
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	54,771,545.34	00.00	54,771,545.34
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	164,465,499.87	76,769,859.56	355,736,403.27	00.00	596,971,762.70

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,317.6 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 1,317.6 мянган төгрөгийн алдааг залруулж, дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа: Томилолтоор явсан албан хаагчдын цалин хөлсийг тооцохдоо хоолны нэмэгдлийг давхардуулан олгосон байна. Энэ нь Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 1,021.6 мянган төгрөгийн 4 зөрчил² илэрснээс 1,021.6 мянган төгрөгийн 4 зөвлөмжийг Хөвсгөл аймгийн Далайн-Элбэрэлт өрхийн эрүүл мэндийн төвийн дарга, нягтлан бодогч нарт хүргүүлсэн. Дээрх зөрчил нь материаллаг бус зөрчил байна.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой асуудал

1.Илрүүлэлт: Өндөр үлдэгдэлтэй эм, эмнэлгийн хэрэгсэлд тооллого хийхэд хадгалах хугацаа дууссан ковидын оношлуур, нүдний шил, нэг удаагийн хувцас /комбинезон/, маск зэрэг Эрүүл мэндийн газраас 2023 оны 11 дүгээр сард үнэ төлбөргүй хуваарилсан хэрэгслүүд байна. Хугацаа дууссан эм, хэрэгслийг тусгаарлаж, ялгаж тэмдэглэсэн тэмдэглэгээ, сав баглаа боодолгүй, агуулахад хадгалаатай байна. Энэ нь Эрүүл мэндийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “Үйл ажиллагаандаа чанарын стандартын шаардлагыг хангах” гэж заасныг зөрчсөн, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Агуулахад хадгалаатай байгаа эм, эмнэлгийн хэрэгсэлд хяналт хэрэгжүүлэх ажлын хэсэг томилж, хугацаа дууссан бүтээгдэхүүнийг олж тогтоон нэр төрөл, үнэ, хэзээ хаанаас авсан зэрэг мэдээлэл бүхий жагсаалт үйлдэж, Эрүүл мэндийн сайдын 2011 оны 158 дугаар тушаалаар баталсан “Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, халдваргүйтгэх, устгах заавар”-ын дагуу хугацаа дууссан тэмдэг тэмдэглэгээ хийж тусгаарлан, устгалыг журмын дагуу шийдвэрлэх.

2.Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус байгууллагад мөрдлөг болгон ажиллаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн хэлбэрт шилжсэн болон боловсролын салбарын хууль эрх зүйн шинэчлэлд нийцүүлэн шинэчлэн боловсруулж ажиллаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэж заасанд нийцээгүй, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг холбогдох хууль тогтоомж, стандартад орсон өөрчлөлтөд нийцүүлэн шинэчлэн боловсруулах.

3. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Далайн-Элбэрэлт өрхийн эрүүл мэндийн төв нь Шилэн дансны тухай хуульд заасны дагуу 2023 оноос эхлэн улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 10 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий ажил, үйлчилгээ гүйцэтгэсэн талаарх мэдээллийг улирал бүр мэдээлэх үүрэгтэй боловч тайлант оны санхүүжилтийг огт мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9-д “Арван сая төгрөгөөс дээш үнийн дүнгээр улс, орон нутгийн төсөв, Засгийн газрын болон орон нутгийн тусгай зориулалтын сан, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, санхүүжилт, Засгийн газар, түүний харьяа байгууллагаас гаргасан бонд, үнэт цаас, өрийн бичиг, баталгаа, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээний дагуу хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр, арга хэмжээний дагуу санхүүжиж байгаа энэ хуулийн 3.1.4, 3.1.5-д заасан этгээд нь нийт төсөвт өртөг, хэрэгжилтийн явц, үе шат, зарлага, санхүүжилтийн мэдээллийг Засгийн газраас тогтоосон журмын дагуу улирал бүр хөрөнгө оруулалт, санхүүжилтээ хүлээн авсан төсвийн байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байрлуулах ба шаардлагатай гэж үзвэл олон нийтийн бусад цахим хуудас, өөрийн цахим хуудсаар давхар мэдээлж болно” гэж заасныг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9-д заасан мэдээллийг улирал бүр, үнэн зөв, иж бүрэн мэдээлж хэвших

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг аудитын тайлан хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 09 дүгээр сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Томилолт, хоол, унааны мөнгө давхардуулан олгосон	1	296.0			1	296.0	1	296.0				
Дүн	1	296.0			1	296.0	1	296.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс				Зөвлөмж	
			Төлбөрийн акт		Албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
НБББББ-тэй холбоотой	1	0					1	0

Хугацаа дууссан эм эмнэлгийн хэрэгсэлд холбогдох арга хэмжээг аваагүй	1	1,021.6					1	1,021.6
Дүн	2	1,021.6					2	1,021.6

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны мэдээлэл огт оруулаагүй.	1	0					1	0
Дүн	1	0					1	0